


БАТЛАВ:

НИЙЛҮҮЛЭГЧ : Г.ҮНЭНБААТАР

ГАРЫН ҮСЭГ: 

БАТЛАВ:

ЗАХИАЛАГЧ: ДЭЛГЭРХАНГАЙ ЗД

ГАРЫН ҮСЭГ: 



**ФЕРМЕР АВТОМАШИН ЗАСВАРЛАХ ГЭРЭЭ**

**Дугаар: 01**

Нэг талаас /захиалагчын нэр/ Дэлгэрхангай сумын ЗДТГ, нөгөө талаас / гүйцэтгэгчийн нэр/ Г.Үнэнбаатар дараах зүйлийг харилцан тохиролцож 2024 он 03 сарын 29 -ны өдрөөс 2024 оны 04 сарын 19-ны өдөр хүртэл энэхүү гэрээг байгуулав.

**Нэг: Нийтлэг үндэслэл:**

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу Засаг даргын Тамгын газартай тус байгууллагын УАЗ Фермер хагас ачааны автомашиныг засварлах захиалагч байгууллага, нийлүүлэгч иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахад, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Энэхүү гэрээ нь Засаг даргын Тамгын газарт үзүүлэх автомашин засварын үйл ажиллагаа хэвийн явагдах үйл ажиллагааг зохион байгуулна.

**Хоёр: Захиалагчын эрх үүрэг:**

1. Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж нийлүүлэгч талд шаардлага тавих эрхтэй.
2. Чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлчилгээ авах эрхтэй. Хэрэв чанарын шаардлага хангахгүй бараа бүтээгдэхүүн сэлбэг нийлүүлсэн тохиолдолд ажлын 7 хоногийн дотор буцаан өгөх.
3. Нийлүүлэгчийн нэхэмжлэлийг үндэслэн бүтээгдэхүүний үнийг 7 хоногийн дотор дансанд шилжүүлэх үүрэгтэй.

**Гурав: Нийлүүлэгчийн эрх үүрэг:**

1. Нийлүүлэгч санхүүжилтийг авсан хойно гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх .
2. Чанартай сэлбэг бараа, засварын үйлчилгээг хугацаанд нь хөнгөн шуурхай нийлүүлэх үүрэгтэй.
3. Үнэ зах зээлийн ханшаар байх
4. Стандатын дагуу байх
5. Нэг жилийн баталгаа гаргах



**Дөрөв: Бусад зүйл:**

1. Гэрээний хэрэгжилтэнд 2 тал харилцан хяналт тавина.
2. Гэрээ нь 2 тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, асуудлыг талууд харилцан тохиролцож бичгээр үйлдэнэ.
4. Талууд хоорондоо шийдвэрлэж чадаагүй маргаантай асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

**Гэрээг байгуулсан:**

Нийлүүлэгчийг төлөөлж

Ня-бо. *Улаан*.....

Утас: 89768292

РД: ЗД76110913

Захиалагчыг төлөөлж

Ня-бо. *М. Шан*.....

Утас: 88094609

РД: 9033408



**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН УАЗ ФЕРМЕР ХАГАС АЧААНЫ АВТОМАШИНД  
ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

**2024.04.08**

Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2011 оны УАЗ Фермер автомашины мотор, кроп болон бусад эд ангид засвар үйлчилгээ хийж гүйцэтгэлээ.

Дараах засвар үйлчилгээ хийгдсэн:

- Моторт бүрэн ээлж хийсэн
- Бензин насос шинээр тависан
- Моторын лап резин, кропны удирдлагын түлк резин шинээр тависан
- Моторын тосны шүүр, тос шинээр хийсэн
- Свеча, свечаны утас, транзистор, женам, стартер, транслүрийн таг, ротор, бегном бүгд шинээр тависан
- Ган диск, перда диск, сэр диск, сэрээ бүгд шинээр солисон
- Хөргөлтийн системийн батруба бүгд солисон
- Кропны сальник, тос масло солисон
- 4 нум авч цэвэрлэсэн, бүх тавагнууд солиж гагнасан, шоргоолж резин шинээр солисон
- Тэвшний шалыг сэргээж листэн төмрөөр бүтэн шалласан
- Хаалгануудын бариул түгжээ шинээр солисон
- Тоормозны бүх наклад солисон, тэлэгч комоороо солигдсон
- Бөөрний хамгаалалттай 4 шинэ дугуй тавигдсан
- Зүрх арааны сальник солисон, барбаны сальник солисон
- Урд хойд тэнхлэгний тап солисон, тосолгоо хийгдсэн
- 4 амортизатор шинээр солисон
- Яндан бүрэн засварласан
- Шалавч шинээр тависан

Сэлбэг нийлүүлэгч болон засвар үйлчилгээ хийсэн засварчны ажлын хөлсний баримтыг тухай бүр авч тайланд хавсаргасан болно. Засварын ажлын явцыг фото зургаар тухай бүр баталгаажуулан авсан. Моторыг хуучин ГАЗ засварын суурин дээр бий болсон туршлагатай залуучууд дээр очиж боолгосон.

Тайлан бичсэн: ЗДТГ-ын жолооч..........Г.Үнэнбаатар